



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 441

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн өмчөөс шилжүүлсэн Нийслэлийн засаг захиргааны “Хангарди” ордны барилгыг төрийн өмчид хүлээн авч Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газарт эзэмшүүлж, данс бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2.Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Нийслэлийн засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч И.Баатархүү, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сайханбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Газар эзэмших эрх болон, барилгыг /цогцолбор иж бүрдлээр/ шилжүүлэх, хүлээн авч төрийн өмчид бүртгэх;

2.3.Ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж холбогдох зардлыг улсын төсөвт тусгуулах;

2.4.Хөрөнгийн зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005630  
23-r\_huraldaan.docx